

Япон улсын батлан хамгаалах бодлого бүс нутгийн аюулгүй байдалд нөлөөлөх нь

Рэнцэнгийн Энхболд*

Доктор (Ph.D), дарга, хурандаа, Enkh20033@gmail.com
Монгол Улс, Улаанбаатар, Батлан хамгаалах яам,
Орон нутгийн хамгаалалт, дайчилгааны газар

Энхлхагвын Мөнхзаяа

Ахлах мэргэжилтэн, дэд хурандаа, 0802zaya@gmail.com
Монгол Улс, Улаанбаатар, Батлан хамгаалах яам,
Гадаад хамтын ажиллагааны газар

Хураангуй

Японы улс төрд 2025-2026 онд гарч буй өөрчлөлт нь тус улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлын бодлогод мэдэгдэхүйц доржилт үзүүлж байна. Ерөнхий сайд Такаичи Санаэ нь Тайваний талаар хатуу бодлого баримталж, түүнийгээ ил тод илэрхийлж байгаа нь Хятадын зүгээс хүчтэй хариу үзүүлэх шалтаг шалтгаан болоод байна. Япончууд Америктай улс төр, эдийн засаг, батлан хамгаалах салбарын харилцааг улам гүнзгийрүүлж, Хятад, Умард Солонгос, Оросын зүгээс учруулж болох аюул заналхийллийг сөрөх цэргийн хүчин чадлыг бэхжүүлэхийг чармайл боллоо. Үүний тулд Үндсэн хуульдаа 2026 онд нэмэлт өөрчлөлт оруулж болзошгүйгээс гадна үндэсний аюулгүй байдалтай холбоотой стратегийн голлох баримтуудаа шинэчлэх, батлан хамгаалах зардлаа нэмэгдүүлэх, нууцлалтын довтолгооноос хамгаалах цогц системийг хөгжүүлэхэд анхаарал хандуулах нь тодорхой байна.

Япон 2025 онд батлан хамгаалах салбартаа зарцуулах зардлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувьд хүргэх, цэргийн чадавхыг нэмэгдүүлэх, кибер аюулгүй байдлыг бэхжүүлэхэд идэвхтэй бодлого баримтлан ажиллав. Эдгээр бодлогыг хэрэгжүүлэхийн тулд Америк-Японы цэргийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, сансрын орон зай болон кибер орчин дахь аюулгүй байдлын хамгаалалтыг сайжруулах, бүс нутгийн түвшинд хоёр улсын хамтарсан цэргийн ажиллагааны командалыг шинээр байгуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Түлхүүр үгс: Батлан хамгаалах шинэчлэл, Үндсэн хуулийн өөрчлөлт, Зүүн хойд Азийн аюулгүй байдал, Японы дотоод улс төрийн өрнөл

* Холбоо барих зохиогч

Нэг. Японы улс төр, аюулгүй байдал, батлан хамгаалах салбарт 2025 онд өрнөсөн голлох үйл явдлууд

Өнгөрөгч 2025 он олон улсын улс төрийн орчинд төдийгүй Японы хувьд сорилт, өөрчлөлт ихтэй жил байв. Японы дотоод улс төрийн хүрээнд парламентын сонгууль товлогдож, улс төрийн удирдлагад өөрчлөлт гарч, Ерөнхий сайд солигдсон нь бодлогын түвшинд тодорхой шинэчлэл авчирсан. Харин гадаад бодлогын хувьд Америк-Японы стратегийн түншлэл, Энэтхэг, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын орчин, ялангуяа далайн аюулгүй байдлын асуудалд илүү анхаарал хандуулах хандлага тодорчээ. Үүний зэрэгцээ Европын орнууд Энэтхэг-Номхон далайн бүс нутаг дахь стратегийн ашиг сонирхлоо идэвхтэй илэрхийлж эхэлснээр Европын Холбоо, Японы харилцаа өргөжин тэлж, улмаар Японы гадаад болон аюулгүй байдлын бодлогод мэдэгдэхүйц өөрчлөлт гарах нөхцөлийг бүрдүүлжээ.

Японы дотоод улс төр: Ишибагийн тэргүүлсэн Либерал ардчилсан нам 2025 онд дараалсан хоёр сонгуульд амжилтгүй оролцож, огцорсон нь тус намын тэргүүлэгч Такаичи Санаэг Японы Инновацын намтай зөвшилцөлд хүргэхээс аргагүй байдалд хүргэсэн. Такаичи барууны чиг баримжаатай Японы “Инновацын нам”-тай шинэ эвсэл байгуулсан нь Японы улс төрд томоохон доргилт үүсгэсэн. Өөрөөр хэлбэл: Либерал ардчилсан нам болон Комейто намын 26 жил үргэлжилсэн эвсэл задарсан явдал юм. Эрх баригч Либерал ардчилсан нам болон Инновацын намын удирдагчид эвслийн гэрээнд албан ёсоор 2025 оны 10 дугаар сарын 20-нд гарын үсэг зурсан нь түүнийг Японы анхны эмэгтэй Ерөнхий сайдаар сонгох баталгаа болсон юм. Энэхүү үйл явдал нь зөвхөн хүйсийн тэгш байдлыг хангах санаачилгын үр дүнгээс гадна Японы консерватив улс төрийн үзэл баримтлал илүү хатуу байр суурьт шилжсэний илрэл гэсэн тайлбар давамгайлж байна. Такаичи нь Ерөнхий сайд асан Шинзо Абэгийн үзэл баримтлалыг үргэлжлүүлэгч, эдийн засгийн аюулгүй байдал болон батлан хамгаалах салбарын хүчин чадлыг бэхжүүлэхийг тууштай дэмжигч бөгөөд түүний засаглал Японыг илүү үндэсний чиг баримжаатай, бие даасан бодлого руу хөтөлж байна (Аюулгүй байдал судлалын хүрээлэн, 2026).

Осака мужийн захирагч Ёошимүра Хирофүми “Бид нэг үндэсний үзэл баримтлалтай, Япон улсыг хүчирхэгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй байдаг. Инновацын намын хувьд бид өнөөг хүртэл дэмжиж ирсэн шинэчлэлээ урагшлуулахыг хүсэж байна” гэсэн мэдэгдэл хийж байв (Chai, 2025).

Сансейто болон Японы консерватив нам зэрэг “Япон нэгдүгээрт” уриаг сурталчлах шинэ хүчнүүд олон нийтийн дэмжлэгийг авч эхэлсэн нь үндэсний үзэл нэмэгдэж байгааг тод харуулж байв. Япон дахь барууны үндэсний үзэлтэй намуудын сэргэлт нь зөвхөн нэг удаагийн улс төрийн үзэгдэл бус тус улсын нийгэм, эдийн засаг, геополитикийн гүнзгий хямралын хариу үйлдэл гэж үзэж болохоор байна.

Японы аюулгүй байдлын бодлого, түүний хэрэгжилт: Японы аюулгүй байдлын гол тэргүүлэх чиглэл бол Америк, Японы харилцааны өнөөгийн түвшнийг хадгалах, улам бэхжүүлэх явдал юм. Хоёр улсын хооронд 1960 онд шинэчлэн

байгуулсан аюулгүй байдлын гэрээний гол агуулга нь хоёр улсын цэргийн холбоотны харилцааг бэхжүүлэх, хэрвээ аль нэг улс Японд халдвал Америк харилцан хамгаалах тухай заасан байдаг. Гэхдээ бүс нутгийн аюулгүй байдлын тогтолцоо нь дан ганц хоёр улсын хоорондын харилцаагаар тогтохгүй бүс нутгийн бусад оронтой түншлэлийг бэхжүүлэх замаар явдаг тул анхаарах нь зүйтэй.

Сүүлийн хэдэн жилийн хугацаанд Япон улсын Засгийн газрын Ерөнхий сайдууд Кишида, Фүмио, Ишиба нар Абэгийн эхлүүлсэн аюулгүй байдлын талаар илүү идэвхтэй байр суурь баримтлах бодлогыг үргэлжлүүлсэн. Ерөнхий сайд Ишибагийн засаг захиргаа Японы баримталж буй аюулгүй байдлын талаарх шинэ байр суурийг хадгалахыг эрмэлзэж байсан. Тухайлбал: Япон Австралид “Могами ангилал”-ын 11 нэгж фрегатуудыг нийлүүлэх 6.5 тэрбум ам.долларын гэрээг 2025 оны наймдугаар сард байгуулж чадсан нь Японы батлан хамгаалах салбарын нэг онцлох үйл явдал болсон.

Япон улсын Батлан хамгаалахын сайд Накатани Гэн, АНУ-ын Батлан хамгаалахын сайд Пит Хегсеттэй 2025 оны гуравдугаар сард уулзах үеэрээ Өмнөд Солонгос, Зүүн болон Өмнөд Хятадын тэнгисийг “Нэг театр” болгох талаар дурдсан нь анхаарал татсан. Энэ нь Японы зүгээс Хятадын болзошгүй түрэмгийллийн улмаас Тайваньд тохиолдох аюулыг таслан зогсоох, Хятадын зүгээс явуулж буй бусад сөргөлдөгч орныг “жижиглэх тактик”-ийг өргөжүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор байлдааны ажиллагааны нэгдсэн театр байгуулах санааг дэвшүүлсэн (Olav, 2025) -тэй холбоотой.

Японы батлан хамгаалах бодлого, түүний хэрэгжилт: Япон улс нь Энэтхэг-Номхон далайн бүх улстай харилцаагаа хадгалж байхаас гадна сүүлийн жилүүдэд Европын Холбоо, бусад түнш улстай харилцаагаа өргөжүүлж байна. Европын Холбоо-Япон улсын гадаад харилцаа, хамтын ажиллагаа 2019 оноос өргөжиж эхэлсэн бөгөөд хоёр тал хамтын ажиллагаагаа цаашид өргөжүүлэх сонирхолтой. Европын орнуудын төлөөлөл Шангри-Лагийн яриа хэлэлцээнд түлхүү оролцох болсон нь Энэтхэг-Номхон далайн бүсийн аюулгүй байдалд Европын ашиг сонирхол нэмэгдэж буйг, мөн Европ, Азийн аюулгүй байдал харилцан хамааралтай байгаа нь тод харагдах болсон. Тухайлбал: Европт эдийн засгийн аюулгүй байдал, дэвшилтэт технологи, аюулгүй байдлын асуудлаар өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх зорилгоор итгэж болох түнш нь Япон байж болох юм. Мөн Япон Британи, Италитай хамтран зургаадугаар түвшний үл үзэгдэгч сөнөөгч онгоц бүтээх зорилготой нисэх хүчний тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлдэг (Defence, 2023) зэргийг дурдаж болох юм. Мэдээж Японы гадаад харилцааны хувьд “А+” төлөвлөгөө чухал бөгөөд энэ нь Америк, дараа нь “нэмэх” гэдэгт Европын Холбоо, түүний гишүүн орнууд, НАТО орж байна. Япон нь Австрали, Британи, Франц зэрэг улстай аюулгүй байдлын чиглэлд идэвхтэй харилцдаг. Мөн Европын Сансрын агентлаг саяхан Токиод оффисоо нээж, сансар судлалын чиглэлд илүү олон талаар хамтран ажиллах боломжийг бүрдүүлж байна.

Хоёр. Японы улс төр, аюулгүй байдал болон батлан хамгаалах салбарт 2026 онд тохиох чухал үйл явдлууд

Японы улс төр 2026 онд харьцангуй тогтвортой, аюулгүй байдлын талаар идэвхтэй бодлого явуулах нь тодорхой харагдаж байна. Энэ нь Япон улсын Засгийн газрын бодлогын шинэчлэл, бүс нутгийн геополитикийн хурцадмал байдал, Засгийн газрын удирдлагын хараат бус байр суурь зэрэг олон хүчин зүйлсээс шалтгаална. Харин сорилтын хувьд *нэгдүгээрт*, дотоодын улс төр, *хоёрдугаарт*, эдийн засаг гэсэн тэргүүлэх хоёр салбар хэвээр байх төлөвтэй байна.

Японы улс төрийн өрнөл: Ерөнхий сайд Такаичи Санаэ Парламентын доод танхимаа 2026 оны нэгдүгээр сард тарааж, ээлжит бус сонгууль явуулахаар зарласан. Ерөнхий сайд Такаичигаар удирдуулсан Либерал Ардчилсан нам, Инновацын намтай хамтран 2026 оны хоёрдугаар сарын 09-ний өдөр эвсэл байгуулан сонгуульд оролцож, танхимын 465 суудлын 352-ыг буюу нийт суудлын гуравны хоёрын дэмжлэгийг авсан (Khalil & Cheetham, 2025) нь сөрөг хүчний Төв шинэчлэлийн эвслийн өмнөх сонгуулиар авсан суудлынхаа тоог эрс бууруулсан үр дүн юм. Анхны эмэгтэй Ерөнхий сайд Такаичи Санаэ 2026 оныг олон нийтийн өндөр дэмжлэгийг авч, давуу нөхцөл байдалтайгаар эхлүүлж байна. Эрх баригч Либерал ардчилсан намын хувьд ар талд нь бат зогсож байгаа энэ нөхцөлд Ерөнхий сайдын бодлого, үйл ажиллагаа Японы улс төрд гүнзгий нөлөөлөл үзүүлж магадгүй юм.

Японы энэ удаагийн парламентаас хүлээж буй хамгийн том хүлээлт бол 1947 оноос хүчин төгөлдөр үйлчилж буй Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах эсэх асуудал юм. Энэ талаар олон жилийн туршид Японы нийгэм, улс төрийн намууд, иргэдийн дунд хэлэлцэж байгаа. Тухайлбал:

Үндсэн хуулийн 9 дүгээр зүйлд нэмэлт өөрчлөлт оруулах: Одоогийн 9 дүгээр зүйл нь дайн хийх болон зэвсэгт хүчинтэй байхыг хязгаарладаг боловч Япон нь өөрийгөө хамгаалах хүчинтэй. Улс төрийн зарим нам Японы өөрийгөө хамгаалах хүчнийг Үндсэн хуульд албан ёсоор тусгах, эсвэл өөрийгөө хамгаалах эрхийг илүү тодорхой болгох саналыг дэвшүүлдэг.

Онц байдлын тухай заалтыг нэмэх: Гамшиг, дайн, цар тахлын үед Засгийн газрын эрх мэдлийг түр хугацаанд нэмэгдүүлэх тусгай зохицуулалтыг оруулах тухай юм. Гэвч шүүмжлэгчид үүнийг ардчилалд эрсдэлтэй гэж үздэг.

Хүний эрхийн шинэчлэл: Хувийн нууц, мэдээллийн аюулгүй байдал, орчин үеийн технологийн эрхийн асуудлыг тодорхой болгох, мөн байгаль орчны эрхийг Үндсэн хуульд тусгах зэрэг санал бий. Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах үндсэн агуулга нь цэрэгжсэн улс байх хязгаарлалтыг үгүй болгох эсэх асуудал маргаантай сэдэв болж байна.

Мөн Япон улсын Засгийн газраас исламын шашинтай холбоотой асуудлаарх Европын орнуудын сургамж, туршлагад тулгуурлан исламын шашинтай хүн нас барсан тохиолдолд Японд оршуулахгүй байх, олон нийтийн газар замбараагүй

мөргөл үйлдэхийг хориглох зэрэг асуудалд хатуу байр суурь баримтлах болсон нь олон нийтийн тодорхой дэмжлэгийг хүлээгээд байна.

Японы батлан хамгаалах болон аюулгүй байдлын бодлого, үйл ажиллагаа:

Ерөнхий сайд Такаичи Санаэ нь Японы аюулгүй байдлын бодлогын “хатуу чиг шугам”-ыг баримтлагч улс төрч юм. Япон, Америкийн цэргийн эвслийг Японы аюулгүй байдлын тулгуур гэж үздэг. Шинэ Ерөнхий сайд нь батлан хамгаалах бодлогын хувьд хариу цохилт өгөх чадавхыг хууль, бодлогын түвшинд баталгаажуулах, Хятад, Умард Солонгос, Оросын аюул заналд илүү бодитой, хатуу хариу барих, Америк, Австрали, Энэтхэг, Европын ардчилсан орнуудтай хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, Тайваний асуудлаар Хятадын эсрэг ил тод, тодорхой байр суурийг илэрхийлэх, өөрийгөө хамгаалах хүчний эрх зүйн хязгаарлалтыг багасгах, Үндсэн хуулийн 9 дүгээр зүйлийн шинэчлэлийг дэмжих, Японы дайны дараах хамгаалалтын бодлогоос илүү идэвхтэй гадагш чиглэсэн үйл ажиллагаанд шилжих үзэл баримтлал эхлүүлэхийг эрмэлзэж байх магадлалтай юм. Харин Батлан хамгаалахын сайд Койзүми Шинжиро нь зөөлөн, уламжлалт, либерал, олон нийгэд ойлгомжтой, эв нэгдлийг чухалчилсан үзэлтэй улс төрч юм. Тэрээр Япон-Америкийн цэргийн эвслийн одоогийн байр суурийг хадгалах, цэргийн хурц мэдэгдэл болон өдөөн хатгасан бодлогоос аль болох зайлсхийх, сөргөлдөөнийг даамжруулахын оронд бүс нутгийн тогтвортой байдлыг хадгалах бодлогыг баримтлах төлөвтэй. Үүний зэрэгцээ Японы өөрийгөө хамгаалах хүчний бэлэн байдал, технологийн шинэчлэл, хүний нөөцийн чадавхыг сайжруулахад анхаарч, Үндсэн хуулийн 9 дүгээр зүйлд огцом өөрчлөлт хийх, довтлох шинжтэй зэвсэг, техник болон үзэл баримтлалд болгоомжтой хандах байр суурьтай байна.


Одоогоор мөрдөж буй “Үндэсний аюулгүй байдлын стратеги”, “Үндэсний батлан хамгаалах стратеги”, “Батлан хамгаалах салбарыг бэхжүүлэх хөтөлбөр” гэсэн гурван баримт бичгийг шинэчлэх ажлыг 2026 оны хавраас эхлүүлж, тухайн оны 12 дугаар сард батлахаар төлөвлөж байна (The Japan Times, 2026). Тус улс “Батлан хамгаалах стратеги” баримт бичгийг 2022 онд шинэчилсэн хэдий ч дөрвөн жилийн дараа дахин шинэчлэх ажилд оржээ. Энэ нь Умард Солонгосын пуужингийн туршилтууд, Хятадын цэргийн хүчин чадлын өсөлт, Оросын аюулгүй байдлын орчинд гарч буй өөрчлөлттэй шууд холбоотой.

Шинэчлэн батлах “Батлан хамгаалах стратеги”-д “хариу цохилт өгөх чадавх”-ыг сайжруулна гэдэг зорилт чухал байр суурийг эзэлж байгаа. Энэ нь тус улстай сөргөлдөгч этгээд Японд халдах нь тодорхой болсон, эсвэл дайралт эхэлсэн тохиолдолд дайсны пуужингийн байрлал, удирдлагын төв, цэргийн бааз зэрэг довтолгооны эх үүсвэрийг устгах чадавхыг хэлэх бөгөөд тус зорилгоор алсын тусгалтай пуужингийн системийг сайжруулах ажлыг эхлүүлсэн. Тухайлбал: байлдааны усан онгоцны эсрэг “Type 12” пуужингийн[□] алсын тусгалыг сайжруулан 1000 км болгон өөрчлөхөөр ажиллаж байна. Мөн АНУ-аас “Tomahawk” далавчит пуужин худалдан авахаар төлөвлөж байна.

Япон 2025 оны эцсээр 4.3 их наяд ам.долларын ДНБ-ий хэмжээгээрээ дэлхийн тав дахь том эдийн засагтай улс хэвээр үлдсэн. Япон 2026 оны санхүүгийн жилд батлан хамгаалах салбартаа зарцуулах зардлыг 58 тэрбум ам.долларт хүргэж, өмнөх жилээс нэмэгдүүлэхээр төсөвлөжээ (Хүснэгт 1). Мөн Япон улсын Засгийн газар 2027 он гэхэд ДНБ-ий 2 хувийг батлан хамгаалах салбарт зарцуулахаар төлөвлөж байгаа. Үүнд: далайн эргийн “Shield” нэртэй хамгаалалтын системийг бүтээх; агаар, усан мандал болон доорх орчныг хамарсан олон давхар хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэх зорилт тавьжээ.

Хүснэгт 1. Японы өөрийгөө хамгаалах хүчний төсвийн өсөлт

ЯПОНЫ ӨӨРИЙГӨӨ ХАМГААЛАХ ХҮЧНИЙ ТӨСВИЙН ӨСӨЛТ (2020-2029 он)




Эх сурвалж: Японы Батлан хамгаалах яам, Global data Intelligence

Япон-Хятадын харилцаа: Ерөнхий сайд Такаичигийг 2025 оны 11 дүгээр сард хийснээс мэдэгдлээс хойш Япон-Хятадын хооронд стратегийн өрсөлдөөн гүнзгийрч байна. БНХАУ-ын зүгээс Зүүн Хятадын тэнгист (ялангуяа Сенкакү/Дяоюй арлуудын орчим) цэргийн болон эргийн хамгаалалтыг эрс нэмэгдүүлсэн. Япон энэ бүс нутгийг үндэсний аюулгүй байдалд шууд нөлөөлөх эрсдэл хэмээн үзэж, өмнөд арлуудад (Окинава арлын орчим) пуужин, радарын систем, тэнгисийн болон агаарын цэргийн хүч хэрэгслийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч байна. Учир нь Тайваньд онцгой байдал үүссэн тохиолдолд үүнийг Японы үндэсний аюулгүй байдалд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх “онцгой нөхцөл байдал”, “оршин тогтнохуйн аюул заналхийллийн нөхцөл байдал” гэж үзэн, өөрийгөө хамгаалах хүчин нь Америкийн зэвсэгт хүчинд ар тал хангалтын дэмжлэг үзүүлж, өөрийгөө хамгаалах хязгаарлагдмал эрх (сөрөг довтолгоо, хамгаалалт)-ийг хэрэгжүүлэх магадлалтай. Энэхүү нөхцөл байдал нь Сенкакү болон Нансей арлыг дайны бүсэд татах эрсдэл үүсгэж болзошгүй гэсэн болгоомжлолыг төрүүлж байна.

Америк, Япон хамтарсан цэргийн сургуулилтаа өргөжүүлэх, хамтран пуужин үйлдвэрлэх, газрын ховор элементийн хангамжийн сүлжээг тэлэх зэргээр хамтын ажиллагаагаа өргөжүүлж байна. Японы өөрийгөө хамгаалах хүчний зэвсэг, техник, технологи нь Америкийн зэвсгийн системүүдтэй нийцдэг бөгөөд харилцан ажиллагааг дэмжих чадавхтай байгааг онцлох нь зүйтэй. Энэ нь хямралын үед зэвсгийн ашигтай байдал, эсрэг талд хохирол учруулах чадавхыг улам нэмэгдүүлдэг чухал хүчин зүйл юм. Хятадын тал Японыг Америкийн холбоотны нэг төдийгүй бүс нутгийн аюулгүй байдлын архитектурт идэвхгүй ажиглагч байхаа больсон гэж үзэх болсон.

Зураг 1. Японы өөрийгөө хамгаалах хүчний гол байрлалууд, Япон-Хятадын цэргийн хүчний харьцаа



БНХАУ нь батлан хамгаалах зардал, пуужингийн нөөц, тэнгисийн болон агаарын цэргийн хүч хэрэгсэл, тоон үзүүлэлтээрээ Япон улсыг давамгайлдаг. Японы хувьд батлан хамгаалах хүчин чадал тоон үзүүлэлтээрээ Хятадтай эн зэрэгцэх боломжгүй ч, Америкийн цэргийн хүчтэй хамтарсан тохиолдолд хохирол хүлээлгэх чадвар нь Хятадын стратегийн төлөвлөлтөд хүндрэл учруулах эрсдэлтэй.

Японы анхны арлын гинжин хэлхээний дагуух газарзүйн байршил, тагнуул, ажиглалт, туршуул хийх чадавх, пуужингийн довтолгооноос хамгаалах систем нь Зүүн Хятадын тэнгис болон Тайваний эргэн тойронд Хятадын цэргийн ажиллагаанд

мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх боломжийг олгодог. Тухайлбал: Японы эргийн хамгаалалтын пуужингийн ангиуд, орчин үеийн шумбагч завинууд болон “F-35” сөнөөгч онгоцны тоо нэмэгдэхийн хэрээр ХАЧА-ийн хөдөлгөөнийг хязгаарлахын зэрэгцээ давхар хамгаалалтын системийг бүрдүүлдэг.

Стратегийн хувьд Хятад нь Японы батлан хамгаалах чадавхын өсөлтөөс болгоомжлох шалтгаан бий. ХАЧА-ийн стратеги төлөвлөгчид аливаа томоохон хямралд, ялангуяа Тайваньтай холбоотой цагийн байдалд Японы оролцоог нэмэгдүүлэн тооцож, төлөвлөлт хийх нь гарцаагүй юм.

Зүүн Азийн бүс нутагт нөлөөлж буй Японы ашиг сонирхол

Хятад, Умард Солонгос, Оросоос ирж болзошгүй аюул заналхийллийг сөрөх Японы аюулгүй байдлын ашиг сонирхол нь Зүүн Азийн бүс нутгийн геополитикт томоохон өөрчлөлтийг авчирч байна. Батлан хамгаалах зардлаа ДНБ-ий 2 хувь хүртэл өсгөж, хариу цохилт өгөх чадавхаа нэмэгдүүлж, Америктай холбоотны харилцаагаа бэхжүүлснээр Япон “идэвхгүй, амар тайван” улсаас “идэвхтэй, хатуу хүчний” тоглогч болон хувирч байна. Энэхүү өөрчлөлт нь Японы бүс нутаг дахь аюулгүй байдлын эрх ашигт нийцэж байгаа хэдий ч Бээжинд үл итгэх байдлыг улам гүнзгийрүүлж, улмаар Токио-Бээжингийн харилцааг өрсөлдөөний хэмжээнд хүргэж байна. Энэ нь Зүүн Азийн орнуудад нөлөөлөх магадлалтай.

Япон нь Хятадын эсрэг аюулгүй байдлыг тэнцвэржүүлэгчийн үүрэг гүйцэтгэж, бүс нутгийн түншүүддээ Хятадын нөлөөнөөс өөр хувилбар санал болгож, чөлөөт нээлттэй Энэтхэг-Номхон далайн бүс нутгийг дэмжих бодлого баримтлах төлөвтэй байна. Тус улс алсын тусгалтай пуужин худалдан авах, батлан хамгаалах аж үйлдвэрийн баазаа бэхжүүлэх, зэвсгийн экспорт хийх процесс, дүрэм журмыг хялбар болгож байгаа нь дэлхийн II дайнаас хойш баримталж буй “энх тайванч үзэл”-ээс татгалзсаныг илтгэж байна. Япон улс АНУ, Австралийн Холбооны Улс, Зүүн өмнөд Азийн орнуудтай хамтарсан цэргийн сургуулилт хийж, цэргийн үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх болсон нь дээрх бодлого, үйл ажиллагаатай салшгүй уялдаатай.

Дүгнэлт

Япон Улсын Ерөнхий сайд Такаичи Санаэ нь Ерөнхий сайд асан Шинзо Абэгийн баримталж байсан үндэсний аюулгүй байдлын бодлогын үндсэн чиг шугамыг сэргээн үргэлжлүүлэх нь тодорхой харагдаж байна. Энэхүү бодлогын хандлага нь Хятадын цэргийн хүчин чадлын тэлэлтийг тогтоон барих, Америкийн бүс нутаг дахь аюулгүй байдлын ачааллыг бууруулах, мөн Тайваний хоолойд тогтвортой байдлыг хадгалахад Японы гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэхэд чиглэх төлөвтэй байна. Гэвч нөгөө талаас уг чиглэл нь Хятад, хоёр Солонгосын хүчтэй эсэргүүцэлтэй тулгарч, бүс нутаг дахь зэвсэглэлээр өрсөлдөх явцыг хурдасгах,

түүхэн маргаантай асуудлуудыг дахин сэдрээх, улмаар стратегийн үл итгэлцлийг нэмэгдүүлэх эрсдэлийг дагуулах магадлалтай юм.

Япон улс цэргийн хувьд илүү хүчирхэг статустай болох зорилгод чиглэн аюулгүй байдал, гадаад бодлого болон батлан хамгаалах бодлогоо идэвхжүүлэхэд үндсэрхэг өнгө аястай дотоод улс төрийн хандлага тодорхой хэмжээнд нөлөөлж буй нь сүүлийн үеийн шинэлэг хүчин зүйл болж байна. Ийм нөхцөлд Японы одоогийн засгийн газар бүс нутгийн стратегийн тэнцвэрийг хадгалах зорилгоор дараах гол арга хэмжээнүүдэд анхаарах магадлалтай. Үүнд:

1. Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, Өөрийгөө хамгаалах хүчний эрх зүйн байр суурийг илүү тодорхой, баталгаатай болгох;
2. Үүний суурин дээр аюулгүй байдал, батлан хамгаалах салбарын стратегийн гол баримт бичгүүдийг үе шаттайгаар шинэчилж, батлан хамгаалах бодлогын хүрээнд түүхэн чанартай өөрчлөлт хийх, илүү идэвхтэй болон хатуу бодлого хэрэгжүүлэх;
3. АНУ-тай цэрэг-стратегийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлж, БНХАУ-ыг тогтоон барих чиглэл дэх хамтын хүчин чармайлтыг бэхжүүлэх зэрэг болно.

Эх сурвалжийн жагсаалт

Defence, U. M. (2023). *Global Combat Air Programme (GCAP): UK, Italy and Japan partner to deliver next generation combat aircraft*.

Easton, Y. (2025, 10 24). *East Asia Forum*. Retrieved from <https://eastasiaforum.org/2025/10/24/no-feminist-fanfare-for-japans-first-female-prime-minister/>

Japan to begin full-scale security strategy review in spring. (2026, January 9). The Japan Times. (2026, 01 09). Retrieved from <https://www.japantimes.co.jp/news/2026/01/09/japan/japan-security-strategy-review/>.

Khalil, S. &. (2025). *Japan's PM Takaichi on course to win snap election by landslide. BBC News.* Retrieved from <https://www.bbc.com/news/articles/cx2y7d2z29xo>.

Olay, M. (2025 , March 30). *Defense secretary announces U.S. Forces Japan's upgrade to joint force command.* Retrieved from DOD News.

хүрээлэн, А. б. (2026 он 2 сарын 6). *Япон улсын нийгэм, улс төр: 2025-2026.*

Japan's Defense Policy and its implications for regional security

Enkhbold Rentsen*

Doctor (Ph.D), Director, Colonel Enkh20033@gmail.com
Director of the Department Local Defense and Mobilization,
Ministry of Defense of Mongolia Ulaanbaatar, Mongolia

Munkhzaya Enkhkhagva

Lieutenant Colonel, Senior Specialist 0802zaya@gmail.com
Foreign Relations Department, Ministry of Defense of Mongolia Ulaanbaatar, Mongolia

Abstract

The changes in Japanese domestic politics during 2025-2026 are generating significant shifts in the country's defense and security policies. Prime Minister Sanae Takaichi's firm stance on Taiwan and her outspoken political rhetoric have drawn strong criticism from China. At the same time, Japan is seeking to strengthen its military capabilities in response to growing security challenges posed by China, North Korea, and Russia by deepening its political, economic, and defense cooperation with the United States. In this context, Japan is likely to amend its constitution in 2026, revise key national security strategy documents, significantly increase defense spending, and prioritize the development of a comprehensive missile defense system.

In 2025, Japan actively pursued policies aimed at increasing defense expenditures to two percent of its gross domestic product, enhancing military capabilities to respond to potential attacks from adversaries, and strengthening cybersecurity. To implement these policies, a range of measures and initiatives were undertaken, including expanding U.S.-Japan military cooperation, improving security capabilities in space and cyberspace, and establishing a new U.S.-Japan Joint Military Operations Command to respond more effectively to regional threats.

Keywords: *Japan security policy; defense modernization; constitutional revision; U.S.-Japan alliance; regional security;*

* Corresponding author